



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2018 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/42

Булган

Сумын Засаг дарга, Засаг даргын  
Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,  
үнэлгээ хийсэн дүнгийн тухай

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны 89 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны 5 дугаар сарын 15-ны А/280 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 11.1, 11.2 дахь зүйл, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2018 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 03 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг дарга, түүний Тамгын газрын 2017 оны үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг хавсралтаар баталсугай.

2. Сумын Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажилгааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 1 дүгээр байр Хутаг-Өндөр 5,0 сая, 2 дугаар байр Сэлэнгэ 4,0 сая, 3 дугаар байр эзэлсэн Булган сумыг 3.0 сая төгрөгөөр тус бүр шагнаж урамшуулан, өргөмжлөл олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Ууганбаяр/-д даалгасугай.

3. Шагнал урамшуулалд шаардагдах 12.0 сая /арван хоёр/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөнөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Наранжаргал/-д зөвшөөрсүгэй.

4. 3 ширхэг “Өргөмжлөл”-д шаардагдах 300.000 /гурван зуун мянга/ төгрөгийг шагналын мөнгөнөөс суутгаж олгосугай.

5. Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдалд дүгнэлт хийж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг мөрдөж ажиллахыг сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

З.БАТЗОРИГ

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 142 тоот захирамжийн хавсралт



Сумын Засаг дарга, түүний тамгын газрын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ

№	Сумдын нэр	Ерөнхий үнэлгээ оноогоор	Эзэлсэн байр
1	Баян-Агт	3.53	14
2	Баяннуур	4.00	10
3	Бугат	3.41	16
4	Булган	4.38	3
5	Бүрэгхангай	3.59	12
6	Гурванбулаг	3.40	17
7	Дашинчилэн	4.05	6
8	Могод	4.03	8
9	Орхон	3.51	15
10	Рашаант	3.54	13
11	Сайхан	4.03	7
12	Сэлэнгэ	4.39	2
13	Тэшиг	4.17	5
14	Хангал	4.29	4
15	Хишиг-Өндөр	3.94	11
16	Хутаг-Өндөр	4.41	1
17	Хялганат	4.02	9

-----oOo-----